

БАТЛАВ: СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ



З.МӨНГӨНБАГАНА

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨВСГӨЛ СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

Огноо: 2020.02.03

**ҮДИЙН ЦАЙ ХӨТӨЛБӨР НИЙЛҮҮЛЭХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт/ гэрээний нэр: Үдийн цай хөтөлбөр нийлүүлэх

Тендер шалгаруулалт/ гэрээний дугаар: ДГАХСЕБС/202001002

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий Боловсролын сургууль** нь сонгогдсон эрх бүхий тендерт **Үдийн цай хөтөлбөр нийлүүлэх** тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх үйлчилгээний зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50000** төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичиг худалдан авсан төлбөрийн баримтийг Орон нутгийн өмчийн газар ирүүлснээр энэхүү тендерт оролцох эрх үүсэх болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй.

Үнийн саналыг **2020 оны 02 дугаар сарын 28-ны** өдрийн 16 цаг 00 минутаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 02 дугаар сарын 28-ны** өдрийн 16 цаг 30 минутад нээнэ.

Дорноговь аймаг, Хөвсгөл сум, 4-р баг ЕБСургууль

Сургуулийн нярав Б.Отгонтогтох

Холбогдох утас: 99445889

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1.Эрх бүхий тендерт оролцогч** 1.1.Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендерийн иж бүрдэл** 2.1.Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендерт нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:  
(а) Үнийн санал;  
(б) Үнийн бол нийлүүлэлтийн хуваарь;  
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/  
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;  
(д) Оролцогчийн ирүүлэх бусад тендерийн бичиг баримт нь тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт, захиалагчаас өгсөн техникийн тодорхойлолтод заасан материалуудыг бүрдүүлсэн байна.
- 3. Тендерийн үнэ** 3.1.Тендер оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 4. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа** 4.1.Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 5. Алдааг залруулах** 5.1.Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:  
(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;  
(б) үйл ажиллагааны үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үйл ажиллагааны үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;  
(в) нэгж үнийг үйлчилгээний тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.  
5.2.Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 6. Санал болгосон** 6.1.Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

үнэ, түүнийг  
үнэлэх

6.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

6.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

7. Гэрээ  
байгуулах  
эрх олгох  
тухай  
мэдэгдэл

7.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

### Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Улсын бүртгэлийн гэрчилгээ, нотариатаар баталгаажуулсан байх</li> <li>2. Харьяалагдах цагдаа, шүүхийн тодорхойлт</li> <li>3. Харилцагч банкны хугацаа хэтэрсэн өр зээлгүй тухай тодорхойлолт</li> <li>4. Нийгмийн даатгал татварын өргүй тодорхойлолт</li> <li>5. Байгууллагын санхүүгийн тайлан /сүүлийн 1 жил хүртэлх/</li> <li>6. Сүүлийн 1 жил хүртлэх энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан түүнийг чанартай сайн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт</li> <li>7. Тендерийн үнийн саналд хувилбарт үнийн санал ирүүлэхгүй байх</li> <li>8. Хавсралтаар өгөгдсөн техникийн тодорхойлолтыг хүлээн зөвшөөрч мөрдлөгө болгоно.</li> </ol>
ТӨӨЗ 2.1	<p><b>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь</b> Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгээ Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар өөрийн ААН-ийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ.</p> <p><b>Тендер хүлээн авах этгээд:</b> Дорноговь аймгийн Хөвсгөл сум ЕБС</p> <p><b>Байгууллагын хаяг:</b> Дорноговь аймгийн Хөвсгөл сум ЕБС</p> <p><b>Тендер хүлээн авах эцсийн хугацаа:</b> Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-ийн серверийн цагаар тооцогдох тул тендер хүлээн авах хугацаанаас хоцорсон тендерийн материал хүлээн авах боломжгүй.</p> <p><b>Огноо: [2020 оны 02 сарын 28-ны өдөр]</b></p> <p><b>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь [2020 оны 02 сарын 28-ны өдөр [16 цаг 00 минут хүртэл]</b></p>

<b>ТӨӨЗ 2.1</b>	<b>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</b> <b>Байгууллагын хаяг: Хөвсгөл сумын ЕБС</b> Давхар болон өрөөны дугаар: ЕБС-ийн Няравын өрөөнд Огноо: <b>[2020 оны 02 сарын 28-ны өдөр]</b> Цаг: <b>[16 цаг 30 минут хүртэл]</b>
<b>ТӨӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар <b>ҮДИЙН ЦАЙ ХӨТӨЛБӨР НИЙЛҮҮЛЭХ, ДГАХСЕБС/202001002</b>

### Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛТ

Үдийн цай хөтөлбөрт нийлүүлэгдэх хүнсний бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

- 1. Барааны тодорхойлт:** [Эрүүл мэндийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хууль тогтоомж, хүүхдийн хоол тэжээлийн норм, стандартад бүрэн нийцсэн, өдөр бүрийн норм хэмжээг бүрэн хангасан байх.]
- 2. Стандарт:** [Үндэсний болон олон улсын стандартын хамгийн сүүлийн найруулгаар тооцно.]
- 3. Баглаа боодол:** [Анги бүрт тогтоосон цагт хүргэж өгөх ба цайны дараа сав баглаа боодлоо буцааж авна.]
- 4. Бараа хүргэх газар:** [Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЕБС-ийн хичээлийн байр]

#### Үдийн цай хөтөлбөр нийлүүлэх / 22,230.00төгрөг /

№	Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо	Стандарт
1	Аарц	кг	125	MNS-CACA11Б-1998
2	Далайн байцаа	ш	375	MNS ISO 4125-2000
3	Цагаан будаа /25гр/	кг	300	MNS ISO 7301-2000
4	Алаг салат	ш	80	MNS 5075-2001
5	Гурвалжин будаа /650гр/	ш	180	MNS 5272-2003
6	1-р гурил /25гр/	шуудай	15	MNS 0244-2009
7	Үзэм	кг	300	MNS CAC 67-1999
8	Элсэн чихэр	кг	80	MNS CAC 4-1995
9	Масло	кг	80	MNS ISO 1740-2000
10	Төмс	кг	400	MNS 0258-2006
11	Шар лууван	кг	90	
12	Ургамлын тос	ш	60	
13	Сонгино	кг	75	MNS 0260-1982
14	Лууван	кг	180	MNS 0270-1982
15	Байцаа	кг	180	MNS 0255-2007
16	Сармис	кг	30	MNS 0267-1973
17	Чинжүү	кг	80	
18	Хийцтэй цай	ш	200	MNS-5131-2002
19	Монгол цай	ш	14	MNS-5131-2002
20	Давс	кг	35	MNS CAC 150-2007
21	Чацаргана /500гр савласан/	ш	190	MNS0916-2011

22	Зөв аарц	литр	500	MNS4229-2011
23	Хуурай сүү /500гр/	ш	200	MNS 4228- 2011
24	Перец	ш	10	
25	Талх	ш	20	MNS 4661-2009
26	Үхрийн мах	кг	680	MNS-5023-2001
27	Хошуу тариан боорцог	гр	238	MNS2488-98
28	Мини гөөхий	гр	204	MNS2488-98
29	Зочин боорцог	гр	79	MNS2488-98
30	Сүүтэй пулогка	гр	500	MNS2488-98

## Тав. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 1. Шалгах болон турших

1.1 Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.

### 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт

2.1 Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.

### 3. Оюуны өмчийн эрх

3.1 Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.

### 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх

4.1 Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.

### 5. Баталгаат засварын хугацаа

5.1 Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа **[тоо]** жил байна.

### 6. Гэрээнд өөрчлөлт оруулах

6.1 Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.

### 7. Төлбөр

7.1 Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **[ГТН-д заасан тоо]** хоногийн дотор шуурхай хийнэ.

### 8. Бараа нийлүүлэх хуваарь

8.1 Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.

## 9. Алданги оногдуулах

9.1 Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна.

## 10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах

Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.

10.1 Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна

## 11. Маргааныг шийдвэрлэх

11.1 Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

### 1. Шалгах болон турших (ГЕН – 1)

[Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх 1.1. шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]

### 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)

2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:

- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
- 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
- 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
- 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
- 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

### 3. Баталгаат засвар (ГЕН-5)

[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]

### 4. Төлбөр (ГЕН – 7)

7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: Гэрээний үнийн дүнгийн **[100]**

<sup>1</sup> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

## Долоо. Жишиг маягт

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.

2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [моо] хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.

3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

\_\_\_\_\_

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг,  
тамга: \_\_\_\_\_

Албан тушаал, нэр:

\_\_\_\_\_

Хаяг: \_\_\_\_\_

—



## 2. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### БАТЛАВ.

#### ЗАХИАЛАГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

#### ГҮЙЦЭТГЭГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр]** (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “ажил” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс :

Улсын төсвөөс: 200.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 200.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 200.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 200.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 200.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 200.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг

\_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

Үнийн санал;

Гэрээний тусгай нөхцөл;

Гэрээний ерөнхий нөхцөл;

Техникийн тодорхойлолт;

Зураг;

Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь<sup>2</sup>;

Санхүүжилтийн хуваарь;

Ажил гүйцэтгэх хуваарь;

Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

2. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

3. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

4. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

5. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

## **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

## **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]\_\_\_\_\_

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

<sup>2</sup>Нэгжүнийгэрээнд “үешатнаажлынхуваарь” гэснийг “ажлынтоохэмжээ” гэжсолино.

<sup>3</sup>Хоёрталхарилцантохиролцожгэрээнийнөхцөлдоруулсанзайлшгүйшаардлагатайнэмэлт, өөрчлөлтүүд.